

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн 21 дүгээр цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй тайлан

Аудитын код: ОРА-2023/77/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn	Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn
Эрдэнэт хот 2023 он	Аудитын менежер: Б.Буян-Ундрах Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn
	Аудитор: Б.Пүрэвсүрэн Утас: 70353717 Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2023.02.24 № 74

танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН 21 ДҮГЭЭР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Р.ЦЭВЭЛСҮРЭН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн 21 дүгээр цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн 21 дүгээр цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Орхон аймгийн 21 дүгээр цэцэрлэг нь элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн цаашид ашиглах боломжтой 6,481.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг дахин үнэлж, санхүүгийн тайланд тусгасан байна.

Аудитын гол асуудал

Боловсролын байгууллага гүйцэтгэлд суурилсан төсвөөр санхүүжих болсноор сургуулийн өмнөх боловсрол хөтөлбөрөөс хэрэгжүүлэх арга хэмжээ 6 болж, зардлын зүйл анги багасаж, ихэнх зардал бараа үйлчилгээний бусад зардлаас зарцуулахаар болсон байна.

Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт "Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал"-ын 8.7-д "Боловсролын сургалтын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд шилжүүлнэ" гэж заасны дагуу зарцуулагдаагүй 17,669.7 мянган төгрөг тус байгууллагын харилцах дансанд үлдэгдэлтэй байна.

Бусад асуудлын хэсэг

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй аудиторт аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>64,449,535.07</u>	<u>85,436,276.54</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	179,492.00	17,669,763.22
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	179,492.00	17,669,763.22
3121	Төгрөг	179,492.00	17,669,763.22
31211	Төрийн сангийн харилцах	-	17,669,763.22
33	АВЛАГА	-	790,870.28
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	790,870.28
35	БАРАА МАТЕРИАЛ	64,270,043.07	66,975,643.04
351	Түүхий эд материал	63,337,143.04	66,975,643.04
35110	Тусгай зориулалттай материал	63,337,143.04	66,975,643.04
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,449,327,274.75</u>	<u>2,444,648,639.33</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,449,327,274.75	2,444,648,639.33
392	Биет хөрөнгө	2,013,903,941.31	2,009,362,805.85
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,150,745,035.50	2,150,745,035.50
39202	Хуримтлагдсан элэгдэл	(170,553,649.11)	(231,216,066.87)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	57,832,734.00	107,939,271.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(34,702,243.16)	(29,229,426.12)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	41,925,824.00	38,796,730.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(31,343,759.92)	(27,672,737.66)
393	Биет бус хөрөнгө	435,423,333.44	435,285,833.48
39301	Програм хангамж	900,000.00	900,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(716,666.56)	(854,166.52)
39303	Бусад биет бус хөрөнгө	435,240,000.00	435,240,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,513,776,809.82</u>	<u>2,530,084,915.87</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,513,776,809.82</u>	<u>2,530,084,915.87</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,513,776,809.82	2,530,084,915.87
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,445,644,891.41	1,445,644,891.41
51101	Өмч: - төрийн	1,445,644,891.41	1,445,644,891.41
512	Хуримтлагдсан үр дүн	(509,257,708.43)	(492,949,602.38)
51210	Өмнөх үеийн үр дүн	(509,257,708.43)	(3,022,033,845.97)
51220	Тайлант үеийн үр дүн	-	2,529,084,243.59
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,577,389,626.84	1,577,389,626.84
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,513,776,809.82</u>	<u>2,530,084,915.87</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	703,918,900.00	3,425,724,747.82
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	42,458,200.00	2,582,081,547.82
120	Нийтлэг татварын бус орлого	42,458,200.00	2,582,081,547.82
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	42,089,100.00	2,582,081,547.82
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	369,100.00	0.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	73,600.00	64,548,440.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	42,015,500.00	2,450,389,874.75

120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		67,143,233.07
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	661,460,700.00	843,643,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	610,896,100.00	756,815,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	756,815,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	49,839,600.00	86,828,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	49,839,600.00	86,828,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	749,475,786.78	896,640,504.23
21	УРСГАЛ ЗАРДАЛ	749,475,786.78	896,640,504.23
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	740,337,878.26	888,188,736.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	501,418,516.51	571,349,611.85
210101	Үндсэн цалин	363,714,446.51	425,467,559.05
210102	Нэмэгдэл	99,590,550.00	128,928,398.78
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,014,400.00	155,600.00
210104	Урамшуулал	37,099,120.00	16,798,054.02
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	67,186,310.26	70,632,058.56
210201	Тэтгэврийн даатгал	46,863,911.42	45,542,577.59
210202	Тэтгэмжийн даатгал	5,168,799.71	8,226,090.89
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,040,959.79	4,436,129.44
210204	Ажилгүйдлийн даатгал	1,010,239.92	1,249,081.79
210205	Эрүүл мэндийн даатгал	10,102,399.42	11,178,178.85
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,479,100.86	42,099,148.28
210301	Гэрэл, цахилгаан	5,102,912.37	7,348,783.03
210302	Түлш, халаалт	20,284,780.33	21,336,847.32
210303	Цэвэр, бохир ус	10,091,408.16	13,413,517.93
2104	Хангамж, бараа материалын зардал	22,336,405.00	6,166,992.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	5,224,992.00
210408	Бараа материал акталсны зардал	18,902,525.00	942,000.00
2105	Нормативт зардал	34,925,016.00	99,341,700.00
210502	Хоол, хүнс	34,605,016.00	99,341,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,987,640.00	4,902,950.00
210604	Урсгал засвар	5,384,200.00	4,902,950.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,122,800.00	1,924,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,924,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	69,882,089.63	91,772,275.45
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	500,000.00	13,131,100.03
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,499,475.00	8,351,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	66,882,614.63	70,289,675.42
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,137,908.52	8,451,768.09
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	6,046,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	6,046,400.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,137,908.52	2,405,368.09
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,137,908.52	2,405,368.09
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(45,556,886.78)	2,529,084,243.59
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(567,000.00)	0.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(46,123,886.78)	2,529,084,243.59

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	661,460,700.00	844,791,675.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	661,460,700.00	844,791,675.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	610,896,100.00	756,815,000.00

131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	756,815,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	49,839,600.00	86,828,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	49,839,600.00	86,828,200.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	1,148,475.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	1,148,475.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	661,460,700.00	827,301,403.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	661,460,700.00	827,301,403.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	652,322,791.48	817,701,160.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	503,539,000.00	571,349,611.85
210101	Үндсэн цалин	372,204,445.00	425,467,559.05
210102	Нэмэгдэл	85,704,102.00	128,928,398.78
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,534,993.00	155,600.00
210104	Урамшуулал	37,095,460.00	16,798,054.02
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	65,138,164.62	70,632,058.56
210201	Тэтгэврийн даатгал	46,576,458.70	45,542,577.59
210202	Тэтгэмжийн даатгал	4,650,051.48	8,226,090.89
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,709,881.19	4,436,129.44
210204	Ажилгүйдлийн даатгал	927,470.29	1,249,081.79
210205	Эрүүл мэндийн даатгал	9,274,302.96	11,178,178.85
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,479,100.86	42,099,148.28
210301	Гэрэл, цахилгаан	5,102,912.37	7,348,783.03
210302	Түлш, халаалт	20,284,780.33	21,336,847.32
210303	Цэвэр, бохир ус	10,091,408.16	13,413,517.93
2104	Хангамж, бараа материалын зардал	3,185,930.00	2,321,492.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	698,800.00	2,321,492.00
2105	Нормативт зардал	35,198,896.00	99,341,700.00
210502	Хоол, хүнс	33,237,196.00	99,341,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,384,200.00	4,902,950.00
210604	Урсгал засвар	5,384,200.00	4,902,950.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,122,800.00	1,924,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,924,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,274,700.00	25,130,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	500,000.00	16,700,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,774,700.00	8,430,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,137,908.52	9,600,243.09
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	7,194,875.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	-	1,148,475.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	6,046,400.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,137,908.52	2,405,368.09
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,137,908.52	2,405,368.09
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	≡	17,490,271.22
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	17,490,271.22
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		179,492.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	179,492.00	17,669,763.22

4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,445,644,891.41	1,577,389,626.84	-	3,023,034,518.25
8	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,445,644,891.41	1,577,389,626.84	(509,257,708.43)	2,513,776,809.82
1	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,445,644,891.41	1,577,389,626.84	(509,257,708.43)	2,513,776,809.82
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(2,512,776,137.54)	(2,512,776,137.54)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,445,644,891.41	1,577,389,626.84	(3,022,033,845.97)	1,000,672.28
8	Тайлант үеийн үр дүн	-	-	2,529,084,243.59	2,529,084,243.59
9	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,445,644,891.41	1,577,389,626.84	(492,949,602.38)	2,530,084,915.87

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	756,815,000.00	739,145,236.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	756,815,000.00	739,145,236.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	750,760,200.00	733,098,836.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	551,450,500.00	539,899,278.22
210101	Үндсэн цалин	451,340,000.00	397,978,197.42
210102	Нэмэгдэл	86,064,600.00	125,504,676.78
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	0.00
210104	Урамшуулал	14,045,900.00	16,416,404.02
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	70,055,900.00	66,803,658.56
210201	Тэтгэврийн даатгал	47,638,100.00	42,939,377.59
210202	Тэтгэмжийн даатгал	5,604,400.00	7,919,690.89
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,483,600.00	4,190,929.44
210204	Ажилгүйдлийн даатгал	1,120,900.00	1,187,881.79
210205	Эрүүл мэндийн даатгал	11,208,900.00	10,565,778.85
2105	Нормативт зардал	102,177,000.00	99,341,700.00
210502	Хоол, хүнс	102,177,000.00	99,341,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,924,000.00	1,924,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,924,000.00	1,924,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,152,800.00	25,130,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,722,800.00	16,700,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,430,000.00	8,430,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,054,800.00	6,046,400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,054,800.00	6,046,400.00

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,054,800.00	6,046,400.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	756,815,000.00	756,815,000.00
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	756,815,000.00	756,815,000.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	756,815,000.00	756,815,000.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	17,669,763.22

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	91,733,900.00	84,422,831.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	91,733,900.00	84,422,831.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	91,733,900.00	84,422,831.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	35,295,700.00	31,450,333.63
210101	Үндсэн цалин	26,088,600.00	27,489,361.63
210102	Нэмэгдэл	3,552,500.00	3,423,722.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,169,600.00	155,600.00
210104	Урамшуулал	4,485,000.00	381,650.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,888,800.00	3,828,400.00
210201	Тэтгэврийн даатгал	3,324,200.00	2,603,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	391,300.00	306,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	313,100.00	245,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	78,200.00	61,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	782,000.00	612,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,455,400.00	42,099,148.28
210301	Гэрэл, цахилгаан	9,462,700.00	7,348,783.03
210302	Түлш, халаалт	25,844,700.00	21,336,847.32
210303	Цэвэр, бохир ус	9,148,000.00	13,413,517.93
2104	Хангамж, бараа материалын зардал	2,142,000.00	2,142,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,142,000.00	2,142,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,952,000.00	4,902,950.00
210604	Урсгал засвар	4,952,000.00	4,902,950.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	91,733,900.00	84,422,831.91
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	91,733,900.00	84,422,831.91
320001	Орон нутгийн төсвөөс	91,733,900.00	84,422,831.91

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,284.3 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 3,284.3 мянган төгрөгийн алдааг залруулж тайлагналаа.

Үүнд: Бараа материалын дансанд сорил гүйцэтгэхэд 1,938.6 мянган төгрөгийн бичиг хэргийн материалыг бусад хангамжийн материалын дансанд дансанд, 696.8 мянган төгрөгийн барилгын материалыг сэлбэг хэрэгслийн дансанд, 648.9 мянган төгрөгийн тусгай

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

зориулалтын материалыг аж ахуй материалын дансанд тус тус тайлагнасан байсныг залруулав.

Аудитаар нийт 972.7 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 50.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 131.8 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 790.8 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Багшийн хөгжлийг дэмжих цахим хэрэглээний зардал болох үүрэн телефоны дата багцыг сонгон хэрэглэхдээ журамд заагаагүй 2 албан хаагчид 50,000.0 төгрөгийн дата ашиглуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12.1-д “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно.”, 12.1.1-т “гар утасны зардал”, Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170 дугаар тушаалаар баталсан “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн цахим хэрэглээний зардлыг төлөвлөх хуваарилах заавар”-ын 2.4-д “дата багцыг сонгосон нөхцөлд цахим хэрэглээний нийт зардлыг нийт үндсэн багш (бүлгийн болон хөгжим, биеийн тамирын багшийн нийт тоо) тоонд хувааж тухайн хугацаанд ашиглах цахим хэрэглээний зардлын нэгжийг тооцно” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй тул төлбөрийн акт тогтоож байна.

1.2 Албан шаардлага

1. Цалинг тооцохдоо ажил хавсран гүйцэтгэж буй ажилчдын ажилласан хоногийг зөрүүтэй тооцон 74.5 мянган төгрөг илүү, 57.3 мянган төгрөг дутуу олгож нийт, 131.8 мянган төгрөгийн зөрүүтэй тооцсон байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 56.1-д "Ажил олгогч нь ажилтантай тохиролцсоноор ажил хослон гүйцэтгүүлэх, эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгүүлэх, ажилтны ажлын цагт багтаан өөр ажил, албан тушаал хавсран гүйцэтгүүлэх, ажлын ачааллыг нэмэгдүүлэх хэлбэрээр ажиллуулж болно", 56.2-д "Энэ хуулийн 56.1-д заасны дагуу ажиллах ажилтанд гүйцэтгэх ажил үүрэгт нь тохирох цалин хөлсийг нэмж олгоно" гэж заасныг зөрчсөн байна.
2. Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, тайлант хугацаанд мэдээлбэл зохих 161 талбарын мэдээллээс 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1.-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3.-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дансны үлдэгдэл үндсэн хөрөнгөтэй холбоотой

Илрүүлэлт: Тайлангийн хугацаанд хагас жилийн болон жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийгддэг ч 2023 оны 2 дугаар сарын 3-нд биет тооллогыг хийхэд эд хариуцагчийн карт нэмэгдсэн хасагдсан хөрөнгийн шинэчлэлт хийгдээгүй, хөрөнгө коджуулаагүй, хөрөнгийн шинж чанарыг үнэн зөв тодорхойлоогүй байна.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73.2-д "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар "Маягт заавар батлах тухай", 2018 оны 100 дугаар тушаал "Аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн маягт, хөтлөх аргачлал"-ыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Эд хариуцагчийн картад нэмэгдсэн хасагдсан хөрөнгийн шинэчлэлтийг хийж, эд хөрөнгийг коджуулах, хөрөнгийн шинж чанарыг үнэн зөв тодорхойлох, өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах.

2. Авлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлангийн хугацааны эцэст 790.8 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөг/ Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бараа материалын дансанд сорил гүйцэтгэхэд 1 938.6 мянган төгрөгийн бичиг хэргийн материалыг бусад хангамжийн материалын дансанд дансанд, 696.8 мянган төгрөгийн барилгын материалыг сэлбэг хэрэгслийн дансанд, 648.9 мянган төгрөгийн тусгай зориулалтын материалыг аж ахуй материалын дансанд тус тус тайлагнасан байна.	1	3,284.3			1	3,284.3	1	3,284.3				
Дүн	1	3,284.3			1	3,284.3	1	3,284.3				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөг/ Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Багшийн хөгжлийг дэмжих цахим хэрэглээний зардал болох үүрэн телефоны дата багцыг сонгон хэрэглэхдээ журамд заагаагүй 2 албан хаагчид датаг ашиглуулсан байна.	1	50.0	1	50.0								
2023 оны 2-р сарын 3-нд биет тооллогыг хийхэд эд хариуцагчийн карт нэмэгдсэн хасагдсан хөрөнгийн шинэчлэлт хийгдээгүй, хөрөнгө коджуулаагүй мөн хөрөнгийн шинж чанарыг үнэн зөв тодорхойлоогүй байна.	1	-					1	-				
Цалинг тооцохдоо ажил хавсран гүйцэтгэж буй ажилчдын ажилласан хоногийг зөрүүтэй тооцсон байна.	1	131.8			1	131.8						
Тайлангийн хугацааны эцэст авлагын үлдэгдэлтэй байна.	1	790.8					1	790.8				
Дүн	4	972.6	1	50.0	1	131.8	2	790.8				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүйгээс тайлант хугацаанд мэдээлбэл зохих 161 талбарын мэдээллээс 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	1	-			1	-		
Дүн	1	-			1	-		

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			